



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны тавдугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/032/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН ХЭРХ
ТОСГОНЫ ТАВДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ШИНЭЧИМЭГ ТАНАА

2026.02.25 № СЭА-2026/032/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны тавдугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Мандал сумын Хэрх тосгоны тавдугаар цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/228 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 14,034.6 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 5 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.7 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	121,855,505.75	14,359,530.91
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		121,855,505.75	14,359,530.91
3121	Төгрөг		121,855,505.75	14,359,530.91
31211	Төрийн сангийн харилцах		121,855,505.75	14,359,530.91
33	АВЛАГА	5	1,548,041.46	359,200.28
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		1,548,041.46	359,200.28
35	БАРАА МАТЕРИАЛ	6	97,558,909.14	114,934,009.14
351	Түүхий эд материал		268,500.00	218,500.00
3513	Эм боох материал		268,500.00	218,500.00
354	Хангамжийн материал		97,290,409.14	114,715,509.14
3541	Бичиг хэргийн материал		1,299,000.00	9,521,800.00
3542	Аж ахуйн материал		74,511,340.20	84,415,280.20
3545	Барилгын засварын материал		973,721.00	973,721.00
3546	Хүнсний материал		1,591,348.00	889,708.00
3547	Бусад хангамжийн материал		18,914,999.94	18,914,999.94
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		220,962,456.35	129,652,740.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,285,436,518.90	1,481,039,063.94
392	Биет хөрөнгө		1,218,176,518.90	1,412,559,063.94
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,088,757,868.50	1,477,606,576.50
39202	Хуримтлагдсан элэгдэл		(157,160,423.12)	(178,948,476.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		80,673,175.20	81,812,629.20
39206	Хуримтлагдсан элэгдэл		(23,782,541.99)	(27,668,898.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		55,900,334.56	65,545,775.16
39208	Хуримтлагдсан элэгдэл		(37,149,444.92)	(27,398,019.11)
39209	Зам, гүүрийн байгууламж		18,774,347.04	18,174,347.04
39210	Хуримтлагдсан элэгдэл		(2,849,999.77)	(3,636,814.93)
39214	Бусад үндсэн хөрөнгө		10,729,530.00	10,621,530.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(7,647,197.68)	(6,748,583.68)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		188,731,873.00	
39217	Ном		3,198,998.08	3,198,998.08
393	Биет бус хөрөнгө		67,260,000.00	68,480,000.00
39301	Программ хангамж		1,400,000.00	1,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(1,340,000.00)	(120,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		67,200,000.00	67,200,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,285,436,518.90	1,481,039,063.94
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,506,398,975.25	1,610,691,804.27
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9		3,689,415.25
413	Өглөг			3,689,415.25
4131	Ажилчидтай холбогдсон өглөг			1,728,362.25
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг			1,961,053.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР			3,689,415.25
51	Засгийн газрын хувь оролцоо		1,506,398,975.25	1,607,002,389.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		163,386,561.24	163,386,561.24
51101	Өмч: - төрийн		163,386,561.24	163,386,561.24
512	Хуримтлагдсан үр дүн		1,161,427,190.03	1,262,030,603.80
5121	Өмнөх үеийн үр дүн		1,161,427,190.03	972,695,317.03
5122	Тайлант үеийн үр дүн			289,335,286.77
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		181,585,223.98	181,585,223.98
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,506,398,975.25	1,607,002,389.02
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,506,398,975.25	1,610,691,804.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,305,572,373.27	1,354,052,658.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,183,731,500.00	1,235,105,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,183,731,500.00	1,235,105,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		5,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		116,840,873.27	118,947,458.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		116,840,873.27	118,947,458.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		34,859,909.98	461,926,637.00
120	Нийтлэг татварын бус орлого		34,859,909.98	461,926,637.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		15,469,910.04	412,786,837.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		19,389,999.94	49,139,800.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	1,340,432,283.25	1,815,979,295.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,253,787,268.28	1,526,644,008.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,235,284,068.28	1,517,529,807.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		822,429,018.54	1,054,614,843.86
210101	Үндсэн цалин		520,234,609.89	625,205,514.13
210102	Нэмэгдэл		267,704,813.65	357,052,838.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт			30,720,000.00
210104	Урамшуулал		34,489,595.00	41,636,491.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		101,463,849.86	126,365,913.41
210201	Тэтгэврийн даатгал		70,371,810.81	85,812,771.54
210202	Тэтгэмжийн даатгал		8,383,155.10	10,147,166.43
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,982,004.84	5,074,350.09
210204	Ажилгүйдлийн даатгал		3,306,403.14	5,074,354.98
210205	Эрүүл мэндийн даатгал		14,420,475.97	20,257,270.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		100,226,073.27	102,288,743.71
210301	Гэрэл, цахилгаан		7,504,200.63	10,253,271.07
210302	Түлш, халаалт		84,289,712.64	84,289,712.64
210303	Цэвэр, бохир ус		8,432,160.00	7,745,760.00
2104	Хангамж, бараа материалын зардал			2,548,260.00
210408	Бараа материал акталсны зардал			2,548,260.00
2105	Нормативт зардал		107,530,072.00	107,157,580.00
210502	Хоол, хүнс		107,530,072.00	107,157,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		16,614,800.00	16,658,715.00
210604	Урсгал засвар		16,614,800.00	16,658,715.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,127,400.00	5,212,189.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,127,400.00	5,212,189.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		84,892,854.61	102,683,562.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		37,400,695.40	35,212,084.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		7,386,600.00	21,312,656.66
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		40,105,559.21	46,158,822.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		18,503,200.00	9,114,201.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		18,503,200.00	9,114,201.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		18,503,200.00	9,114,201.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	1,253,787,268.28	1,526,644,008.94
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		86,645,014.97	289,335,286.77
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)			
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		86,645,014.97	289,335,286.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,305,572,373.27	1,355,517,996.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,305,572,373.27	1,355,517,996.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,183,731,500.00	1,235,105,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,183,731,500.00	1,235,105,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	116,840,873.27	118,947,458.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	116,840,873.27	118,947,458.71
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		1,465,338.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		1,465,338.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,257,065,933.13	1,461,548,633.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,257,065,933.13	1,461,548,633.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,238,562,733.13	1,452,426,033.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	823,977,060.00	1,051,689,241.43
210101	Үндсэн цалин	521,782,651.35	622,279,911.70
210102	Нэмэгдэл	267,704,813.65	357,052,838.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт		30,720,000.00
210104	Урамшуулал	34,489,595.00	41,636,491.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,463,849.86	126,365,913.41
210201	Тэтгэврийн даатгал	70,371,810.81	85,812,771.54
210202	Тэтгэмжийн даатгал	8,383,155.10	10,147,166.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,982,004.84	5,074,350.09
210204	Ажилгүйдлийн даатгал	3,306,403.14	5,074,354.98
210205	Эрүүл мэндийн даатгал	14,420,475.97	20,257,270.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,226,073.27	102,288,743.71
210301	Гэрэл, цахилгаан	7,504,200.63	10,253,271.07
210302	Түлш, халаалт	84,289,712.64	84,289,712.64
210303	Цэвэр, бохир ус	8,432,160.00	7,745,760.00
2105	Нормативт зардал	105,188,060.00	104,494,887.00
210502	Хоол, хүнс	105,188,060.00	104,494,887.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,614,800.00	16,658,715.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	
210604	Урсгал засвар	16,614,800.00	16,658,715.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,547,400.00	5,212,189.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,547,400.00	5,212,189.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,545,490.00	45,716,344.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,459,890.00	35,749,284.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,085,600.00	9,967,060.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,503,200.00	9,122,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,503,200.00	9,122,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,503,200.00	9,122,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	48,506,440.14	(106,030,636.84)
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	48,506,440.14	(106,030,636.84)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		121,855,505.75
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		14,359,530.91

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	163,386,561.24	181,585,223.98	1,161,427,190.03	1,506,398,975.25
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(188,731,873.00)	(188,731,873.00)
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			289,335,286.77	289,335,286.77
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	163,386,561.24	181,585,223.98	1,262,030,603.80	1,607,002,389.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,487,953,200.00	1,355,517,996.71	132,435,203.29	91.1
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,362,020,700.00	1,235,105,200.00	126,915,500.00	90.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,248,078,800.00	1,235,105,200.00	12,973,600.00	99.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	113,941,900.00		113,941,900.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	125,932,500.00	118,947,458.71	6,985,041.29	94.5
132001	Орон нутгийн төсвөөс	125,932,500.00	118,947,458.71	6,985,041.29	94.5
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		1,465,338.00	(1,465,338.00)	
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		1,465,338.00	(1,465,338.00)	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,487,953,200.00	1,355,517,996.71	132,435,203.29	91.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,487,953,200.00	1,461,548,633.55	26,404,566.45	98.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,478,830,600.00	1,452,426,033.55	26,404,566.45	98.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,055,795,400.00	1,051,689,241.43	4,106,158.57	99.6
210101	Үндсэн цалин	664,535,100.00	622,279,911.70	42,255,188.30	93.6
210102	Нэмэгдэл	352,825,800.00	357,052,838.22	(4,227,038.22)	101.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт		30,720,000.00	(30,720,000.00)	
210104	Урамшуулал	38,434,500.00	41,636,491.51	(3,201,991.51)	108.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,703,700.00	126,365,913.41	2,337,786.59	98.2
210201	Тэтгэврийн даатгал	86,626,700.00	85,812,771.54	813,928.46	99.1
210202	Тэтгэмжийн даатгал	10,519,300.00	10,147,166.43	372,133.57	96.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,259,600.00	5,074,350.09	185,249.91	96.5
210204	Ажилгүйдлийн даатгал	5,259,600.00	5,074,354.98	185,245.02	96.5
210205	Эрүүл мэндийн даатгал	21,038,500.00	20,257,270.37	781,229.63	96.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,270,400.00	102,288,743.71	6,981,656.29	93.6

210301	Гэрэл, цахилгаан	11,639,600.00	10,253,271.07	1,386,328.93	88.1
210302	Түлш, халаалт	86,924,500.00	84,289,712.64	2,634,787.36	97.0
210303	Цэвэр, бохир ус	10,706,300.00	7,745,760.00	2,960,540.00	72.4
2105	Нормативт зардал	105,468,500.00	104,494,887.00	973,613.00	99.1
210502	Хоол, хүнс	105,468,500.00	104,494,887.00	973,613.00	99.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,662,100.00	16,658,715.00	3,385.00	100.0
210604	Урсгал засвар	16,662,100.00	16,658,715.00	3,385.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,213,000.00	5,212,189.00	811.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,213,000.00	5,212,189.00	811.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,717,500.00	45,716,344.00	12,001,156.00	79.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,750,400.00	35,749,284.00	12,001,116.00	74.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,967,100.00	9,967,060.00	40.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,122,600.00	9,122,600.00		100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,122,600.00	9,122,600.00		100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,122,600.00	9,122,600.00		100.0
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,487,953,200.00	1,461,548,633.55	26,404,566.45	98.2
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		121,855,505.75	(121,855,505.75)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		14,359,530.91	(14,359,530.91)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1		
3	Төсвийн байгууллага		1		
5	АЖИЛЛАГСДЫН ТОО		37		
6	Удирдах ажилтан		1		
7	Гүйцэтгэх ажилтан		25		
8	Үйлчлэх ажилтан		11		
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)		198	198	
15	Төрийн өмчит СӨБ байгууллага		198	198	
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		37	36	
28	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		24	24	
31	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		1	1	
32	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		1	1	
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)		11	10	

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 37,448.2 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Үр дүнгийн тайланд 1,383.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан,
- Үр дүнгийн тайланд 2,548.3 мянган төгрөгийн акталсан бараа материал, 33,516.5 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлыг үнэ төлбөргүй гарсан /225005/ зардлаар тайлагнасан,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан,

мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга”-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **2,232.6** мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс 504.2 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 1,728.4 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **2,232.6** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 10,305.3 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 6 багшид тус бүр 15-20.0 хувиар тооцон 504.2 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”, “сумын түвшинд 15 хувь”, “аймгийн түвшинд 20 хувь” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

1. Тооцооллын алдаанаас шалтгаалж, тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс 1,728.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын өр төлбөр үүсгэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Дээрх зөрчлийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан	1	1,383.4	1	1,383.4			1	1,383.4				
Үр дүнгийн тайланд зардлыг буруу ангилж, бүртгэсэн	1	36,064.8			1	36,064.8	1	36,064.8				
Дүн	2	37,448.2	1	1,383.4	1	36,064.8	2	37,448.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг нотлох баримтгүйгээр илүү олгосон	1	504.2	1	504.2								
Тооцооллын алдаанаас шалтгаалж, өр төлбөр үүсгэсэн	1	1,728.4			1	1,728.4						
Дүн	2	2,232.6	1	504.2	1	1,728.4						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Дүн								
Нийт дүн								

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			